



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 01396

Улаанбаатар хот

Нийслэлийн Онцгой байдлын газрын
барилга байгууламж, нийтийн эзэмшлийн
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 104 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/935 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2013 оны 02-07-091/580, 2019 оны 02-07-091/1885 дугаар актуудаар ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороонд байрлах нийт 1,986,391,885 /нэг тэрбум есөн зуун наян зургаан сая гурван зуун ерэн нэгэн мянга найман зуун наян таван/ төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг актлан, данс бүртгэлээсээ хасч, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Онцгой байдлын газар /Ж.Чүлтэмсүрэн/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 10,414,350 /арван сая дөрвөн зуун арван дөрвөн мянга гурван зуун тавин/ төгрөгийн хөрөнгийг борлуулж, орлогыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлж, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Захиргаа санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Рэнцэнбямбад даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050000943

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын
даргын 2020 оны 07 дугаар 06 сарын
.....-ний өдрийн 01/596 тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЖАГСААЛТ

төгрөгөөр

№	Эд хөрөнгийн дүн	Ашигласан жил	Хэмжих нэгж	Биет хэмжээс	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэх өртөг	Нийслэлийн өмчөөс хасах үндэслэл
Барилга байгууламж									
1	Галын депогийн барилга	63	ш	1	1,861,306,319.99	1,861,306,320	17,897,176.17	1,843,409,143.82	НМХГ-ын Улсын байцаагчийн 2013 оны 02-07-091/580, 2019 оны 02-07-091/1885 дугаар актууд
2	Цахилгаан шугам	35	м	4	4,050,000.00	4,050,000	4,050,000.00	-	
3	Дулааны шугам	35	м	60	52,599,000.00	52,599,000	52,599,000.00	-	
4	Цэвэр ба халуун усны шугам	35	м	3	6,900,000.00	6,900,000	6,900,000.00	-	
5	Бохирын шугам	38	м	19	13,696,000.00	13,696,000	13,696,000.00	-	
Барилга байгууламжийн дүн						1,938,551,320	95,142,176,17	1,843,409,143.82	
6	Хайс хашлага	10	М ²	4	188,400.00	188,400	188,400.00	-	
7	Хайс хашлага	10	М ²	2.25	351,378.00	351,378	351,378.00	-	
8	Мод	10	ш	20	4,200.00	84,000	84,000.00	-	
9	Зүлэгжүүлсэн талбай	10	М ²	283.5	3,382,155.00	3,382,155	3,382,155.00	-	
10	Навчит мод	10	ш	1	7,450.00	7,450	7,450.00	-	

11	Шилмүүст мод	10	ш	1	39,070.00	39,070	39,070.00	-
12	Асфальтан талбай /ЧД 10 дугаар ангийн урд талбай	10	М²	532.8	16,929,720.00	16,929,720	16,929,720.00	-
13	Бетондсон зам /НОБГ зүүн тал/	15	М²	232	8,323.00	10,320,520	516,025.98	9,804,494.03
14	Биеийн тамирын талбай	10	ш	1	16,537,872.00	16,537,872	16,537,872.00	-
Нийтийн эзэмшлийн дүн						47,840,565	38,036,070.98	9,804,494.03
Нийт дүн						1,986,391,885	133,178,247.15	1,853,213,637.85